

С. Дашцэвэл

ХЯТАДЫН ЖАНЖЛАХ ҮЗЭЛТНҮҮДЭЭС БНСВУ-ЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ ИРСЭН ЭЗЛЭН ТҮРЭМГИЙЛЭХ БОДЛОГО

Бээжингийн эрх баригчид олон улсын харилцааны үндсэн зарчим, НҮБ-ын дүрмийн заалтыг бүдүүлгээр зөрчиж 1979 оны хоёрдугаар сарын 17-нд БНСВУ-ын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн билээ. Энэ түрэмгийлэл нь тохиолдлын зүйл огтхон ч биш бөгөөд БНСВУ-ыг шунахайран эзлэх гэсэн Хятадын их гүрний уламжлалт санаархлын тод илрэл юм.

Хятадын эрх баригчид тусгаар тогтносон Вьетнам улсыг өөрийн эрхшээлд оруулан эзлэн түрэмгийлэх санаархлаа олон үеийн турш хийж ирсэн түүхтэй.

Мао Зэдүн тэргүүтэй Хятадын эрх баригчид БНХАУ байгуулагдсан цагаас эхлэн Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улсыг өөртөө хавсарган нэгтгэх гэсэн хятадын хаад, цэргийн эрхтэн харгис гоминьданы бодлогыг улам нарийн зальт аргаар хэрэгжүүлэхийг эрмэлзсэн юм.

Тэд хятадын хувьсгалын эхний жилүүдэд юуны өмнө вьетнамын ард түмний хувьсгалт ололт хийгээд түүнээс харийн түрэмгийллийн эсрэг явуулсан баатарлаг тэмцлийг талархан дэмжсэн дүр үзүүлж эд материалын тусламж өгч байсан боловч Вьетнамыг хавсарган нэгтгэх гэсэн хорон санаархлаа маш нуун далдалж байв. Гэвч хятадын их гүрний жанжлах, эзлэн түрэмгийлэх үзэлтний хар санаа нь юуны өмнө БНХАУ-ын хувьсгалын туршлагыг дөвийлгөх хандлагаар илэрч байв.

Тэд 1949 оны эцсээс эхлэн Октябрийн хувьсгалын туршлагын олон улсын ач холбогдлыг бууруулж, ЗСБНХУ-д шинэ нийгэм байгуулсаи туршлагыг зөвхөн хөгжилтэй капиталист орнуудад л тохирох мэтээр суртал нэвтрүүлэг явуулж, хоцрогдсон болон колонийн ард түмэнд сонгодог жишээ болж чадахгүй мэтээр тайлбарлахын хамт өөрийн туршлагын ач холбогдлыг Азийн улс түмэнд гоц дөвийлгөж эхлэсэн нь бүр хятадын хувьсгалын эхний жилүүдэд Азийн улс түмэн, түүний дотор ардчиллын замаар замнаж байсан БНАВУ-ыг дэлхийн социализмаас салган араасаа дагуулахыг санаархсан хэрэг байв.

50-иад оны дундуур хятадын жанжлах үзэлтнүүдийн бодлого бүр ч ил тод болов. 1954 онд Энэтхэг-Хятадын хойгийн асуудлаар хийсэн Женевийн бага хуралд оролцсон Хятадын төлөөлөгчдийн байр суурь нь Энэтхэг-Хятадын хойгт Хятад улс онцгой нөлөөтэй учраас тус хойгийн улс орны асуудлыг шийдвэрлэхэд Хятадын зүгээс «онцгой үүрэг» гүйцэтгэх ёстой гэдгийг дэлхий дахинд «нотлохыг» эрмэлзсэн юм. Энэ нь Хятадын төлөөлөгчид уг бага хурал дээр Вьетнамыг хэсэглэн хуваах гэсэн шинэ колоничлогчид, империалист гүрнүүдийн бодлогыг идэвхтэй дэмжиж байснаас тодорхой харагдлаа. 1954 оны 5-р сарын 12-ны Женевийн хуралдаан дээр Чжоу Эньлай хэлэхдээ: «Солонгосын дайныг төгсгөл болгов. Одоо тийм л арга замаар Энэтхэг-Хятадын хойгийн дайныг дуусгах хэрэгтэй байна»¹ гэсэн бөгөөд «тийм л арга замаар» гэдэг нь Вьетнамыг хуваах замаар гэсэн утга санаа байв. Энэтхэг-Хятадын хой-

¹Международные отношения на Дальнем востоке М., 1978. 154-р тал.

гийн улс орнуудыг хуваагдмал байлгах нь хятадын хэтийн жанжлах төлөвлөгөөнд ашигтай байсанд уг хэргийн хамаг учир оршино. Нөгөө талаар Хятад улс эдийн засгаа сэргээн босгож хөгжүүлэн, батлан хамгаалах хүчин чадлаа зузаатгах шаардлагатай байсан (1949—1957 оны) нөхцөлд Вьетнамыг хэсэглэн хуваах замаар францын колоничлогчдыг Өмнөд Вьетнамд хэвээр байлгах нь нэгдүгээрт, тус районд АНУ нэвтрэн орж Хятадад шууд заналхийлэх боломжийг хаах, хоёрдугаарт, Хойт Вьетнамыг Хятадын хил дээрх аюулгүйн бүс болгон ашиглах зорилгыг тэр үед агуулж байлаа.

Тэр үед хятадын эрх баригчид бас Азийн олон орны нутаг дэвсгэр түүний дотор Вьетнам, Лаос, Кампучи улсын нутгийг бүхэлд нь хятадын «алдагдсан нутаг» хэмээн үзсэн газрын зургийг олон хувиар нээлттэй хэвлэн өсвөр үеийнхний хичээлийн хэрэглэгдэхүүн болгон тараасан явдал санамсаргүй зүйл хараахан биш байлаа. Энэ нь хятадын үндсэрхэх бүлэг юуны өмнө залуу үеийнхний үзэл санааг их гүрний үзлээр хордуулах, улмаар хятадтай айл хөрш орнуудыг эзлэн түрэмгийлж жанжлах гэсэн санаархлаа зөвтгөхөд «түүхэн үндэс» болгож ашиглах гэсэн хорон санаа бүхий явууллага байв. Хятадын түрэмгий санаархлыг илчилсэн бас нэг баримт 1958 онд гарсныг саяхан Вьетнамын «Куандой Нянзян» сонин тэмдэглэсэн юм. Үүнд Вьетнамын засгийн газар албан ёсны газрын зургийг (Францын ноёрхлын үеийнхээр) дахин хэвлэх болсон бөгөөд энэ нь туйлын чухал ажил байсан учир онцгой сайн хийх шаардлагатай байв. Гэтэл Вьетнамд хэвлэлийн дээд нарийвчлалтай машин байсангүй учир түүнийг Хятадад хэвлүүлэхээр болжээ. Хятадын тал уг хүсэлтийг дуртайяа хүлээн авч хэвлээд хэдхэн долоо хоногийн дараа эргүүлэн илгээжээ. Гэтэл хятадууд уг газрын зургийг хэвлэхдээ Вьетнамын хилийг хятадад ашигтайгаар өөрчилсөн байсныг Вьетнамын газарзүйн институт төдөлгүй илрүүлсэн байна. Бээжин үүнийг цагаатган тайлбарлахдаа «Дундад Улс бол вьетнамын ард түмний хилийн соргог харуул бөгөөд манай хоёр ард түмний найрамдал ийм ялимгүй зүйлийн улмаас эвдрэх ёсгүй. Ялангуяа өмнө зүгээс халдсан түрэмгийллийн эсрэг хоёр тал хамтран тэмцэж байгаа өнөө үед бүр ч байж болохгүй»¹ гэжээ. Энэ нь хэрвээ Вьетнамын тал дахин эсэргүүцэл илэрхийлбэл империализмын түрэмгийллийн эсрэг тэмцэлдээ хятадын дэмжлэгийг авах нүүргүй болно гэсэн зүйлийг Вьетнамд сануулсан хэрэг байлаа.

Хятадын эрх баригчид их гүрний жанжлах бодлогоо хэрэгжүүлэхийн тулд 60-аад оноос эхлэн олон улсын коммунист хөдөлгөөнд хагарал гарган өөрийгөө «дэлхийн хувьсгалыг толгойлон манлайлагч» болгохыг мэрийсэн билээ. Энэ үед бээжингийнхэн ВХН-ыг манлайлан өөрийнхөө үзэл суртлын хүрээнд татан оруулж гар хөлөө болгохыг хүчлэн чармайсан юм. Тийм ч учраас Бээжин 60-аад оны эхээр Азийн «II намын бага хурал» гэгчийг зарлан хуралдуулж, дэлхийн коммунист хөдөлгөөний үзэл бодлын эсрэг чиглэсэн 25 зүйлт «программ» гэгчийг тулган хүлээлгэх төлөвлөгөөг боловсруулж ВХН-ыг урив. Гэвч ВХН-ын эсэргүүцэлтэй тулгарсан улмаас хятадын санаархал бүтэлгүй болжээ.² 1963 онд ВХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос олон улсын коммунист хөдөлгөөний эв нэгдлийн асуудлын талаар гаргасан мэдэгдэл³, мөн оны Вьетнам-Чехословакийн хамтарсан мэдэгдэл, ВХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн Во Нгуен Зиапын бичсэн «Манай намын гадаад, дотоод эв нэгдлийн уламжлал хөгжиж байгаа нь» өгүүлэл⁴ зэрэг баримт бичгүүдийн үзэл санаа нь ВХН-аас ХКН-ын удирдагчдын хагалан бутаргах

¹«Куандой Нянзян», 1979. IV. 13.

²Tap chi cong san. No. 4, 1979.

³Nhan dan. 1963. II. 11.

⁴Nhan dan. 1963. II. 21.

тактикийг сөрж, ах дүү социалист орнууд, тэдгээрийн намуудтай тогтоосон уламжлалт холбоо харилцаагаа улам бэхжүүлэх, олон улсын коммунист хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалах байр суурь баримталж байгааг тод харуулжээ. Энэ үеэс эхлэн хятадын эрх баригчид Вьетнамын удирдлагад илэрхий даралт шахалт үзүүлэх арга хэрэглэх болсон юм. Тухайлбал, хятадын хэвлэл БНАВУ-ын тухай материал хэвлэн нийтлэхээ хязгаарлаж, Вьетнамд Чехословакийн ерөнхийлөгчийн хийсэн айлчлалын тухай Вьетнам-Чехословакийн хамтарсан мэдэгдлийн тухай чимээгүй өнгөрүүлснээс гадна 1963 оны 5-р сард БНХАУ-ын дарга Лю Шаоци Вьетнамд очиж ЗХУ, социалист бусад орныг гүтгэн гүжирдсэн зүйл ярьж Вьетнам улс «төвийг сахьсан» бодлого баримталж байна хэмээн шүүмжилж байлаа.¹

Хятадын эрх баригчид энэ үед «хэт хувьсгалч» лоозонгоор халхавч хийж «гуравдахь ертөнцийн» орнуудыг жанжлахыг оролдож эхлэсэн болохоор вьетнамын эх орончдод зэвсэгт тэмцлийн замыг зөвлөж «вьетнамын ард түмэнд зэвсэг барин тэмцэхээс өөр зам байхгүй», энэ талаар «Өмнөд Вьетнамд туйлын аятай таатай нөхцөл бүрдлээ», «өнөөгийн улс төрийн байдал АНУ-ын зүгээс зэвсэгт хатгалгад хүргүүлэхгүй»² гэх мэтээр уриалах болсон байна. Үүний цаана Вьетнамд дайны галыг өргөжүүлж, түүнээс улс төрийн ашиг хонжоо олох гэсэн бээжингийнхний хорон санаа нуугдаж байв. Тийм ч учраас тэд АНУ-д нууцаар «хэрвээ АНУ-ын зэвсэгт хүчин Хятадад халдахгүй бол Энэтхэг-Хятадын хойгийн хэрэг явдалд Хятад улс саад болохгүй» гэж амлаж байжээ. Бээжингийн тооцоолсноор Хятадад шууд халдалгүйгээр Вьетнам дахь дайн үнэхээр ч улс төрийн хувьд Бээжинд туйлын ашиг хонжоотой болно гэж үзжээ. Энэ дайн Хятадын хувьд Бээжингээс Вьетнамыг жанжлах бодлогоо хэрэгжүүлэхэд шинэ нөхцөл байдлыг бий болгохоос гадна АНУ-тай ойртон түншлэхэд улс төрийн хөшүүрэг болох ёстой байв.

Бээжингийн зүгээс ямар ч бодитой эсэргүүцэл ирэхгүйг лавтай мэдэж байсан Вашингтоны эрх баригчид 1964 онд Вьетнамын эсрэг түрэмгий явууллагаа идэвхжүүлж Хойт Вьетнамыг бөмбөгдөж эхлэжээ.

Ийнхүү дайн эхлэмэгц Хятадын эрх баригчид зорилгоо хэрэгжүүлэхийн тулд нэг талаас вьетнамын дайныг сунжруулахыг бүх талаар чармайж, нөгөө талаас дайны хүнд нөхцлийг ашиглан БНАВУ-д үзүүлэх даралт шахалтаа хүчтэй болгохыг оролдов. Бээжингийн тооцоолсноор дайн хэдий чинээ сунжирвал Вьетнамын хүчин чадал төдий чинээ суларч, жанжлах бодлогоо хэрэгжүүлэхэд нь хялбар болох байжээ. Тийм учраас дайны жилүүдэд бээжингийнхэн Вьетнамд хандаж «сүүлчийн вьетнам хүнээ дуустал байлдахыг» ятгаж байв. Энэ үед вьетнамын ард түмний тэмцлийг дэмжих олон улсын хөдөлгөөнийг саатуулахад чиглэсэн бээжингийнхний үйл ажиллагаа ч Вьетнам дахь дайныг сунжруулах гэсэн тэдний зорилготой холбоотой байв.

АНУ-ын нисэх хүчин БНАВУ-ын хот, суурин газрыг зэрлэгээр бөмбөгдөж эхлэсний дараахан агаарын энэхүү дайралтыг эсэргүүцэн Вьетнамд хамтын хүчин чармайлтаар идэвхтэй тусламж үзүүлэх тухай ЗХУ-ын тавьсан саналыг Бээжин эсэргүүцэж, Өмнөд Хятад дахь зарим нэг онгоцны буудлыг хэрэглүүлэхийг үл зөвшөөрөн, Вьетнамд зэр зэвсэг цэргийн техник яаралтай хүргэх зөвлөлтийн тээврийн нисэх хүчинд агаарын гүүр бий болгоход саад хийж байв.³

Үүний зэрэгцээгээр Вьетнамд улс төрийн эрээ цээргүй даралт шахалт үзүүлэхийг оролдов. 1965 онд, өөрөөр хэлбэл БНАВУ-ыг АНУ ид бөмбөгдөж байсан тэр үед Дэн Сяопин Вьетнамд нууцаар очиж зөвлөлтийн

¹ «Жэньминь жибао», 1963. V. 16.

² «Жэньминь жибао», 1964. III. 4.

³Международная жязнь № 5, 1979 г.

тусламжаас бүрэн татгалзахыг ятган «Хятад улс Америкийг эсэргүүцэхэд шаардлагатай бүх тусламжийг өөртөө хариуцан авахад бэлэн байна» гэж мэдэгдсэн¹ нь саяхан илрэв. Вьетнамын биеэ даасан бүрэн эрхт гадаад бодлогод харшилсан Бээжингийн энэ шаардлагаас Вьетнам улс татгалзсаны учир ВХН-ын дарга Хо Ши Ми-нийг «ревизионист» хэмээн Дэн Сяопин шүүмжилсэн юм.² Үүний дараахнаас эхлэн ЗХУ, социалист бусад орны тусламжийг Вьетнамд очиход нь Бээжин удаа дараа бэрхшээл учруулж байв.

Хятадын бодлого, үзэл санааг дагахаас Вьетнам улс эрс татгалзаж биеэ даасан тууштай бодлого баримталж байсан учраас 1966 оноос эхлэн бээжингийнхэн Вьетнам дахь хуацяо нарыг ашиглан Вьетнамын бодлогод даралт шахалт үзүүлж эхлэв. Тэд юуны өмнө хуацяо нараар далимдуулан Мао Зэдүний үзэл санааг түгээх, «соёлын хувьсгал»-ыг экспортлохыг оролдов. Тэд нууц улаан хамгаалагчдыг зохион байгуулж, Вьетнам дахь хятад сургуулиудад «хувьсгалч багш шавь нарын нийгэмлэг» гэгчийг байгуулж, хятад гаралтай хүмүүсийн ажилладаг фабрик, завод, хөдөө аж ахуйн хоршоололд «Мао Зэдүний үзэл санаанаас суралцах бүлэг» байгуулан, «Вьетнамд Мао даргын үзэл санаагаар туслах нь эд материалын тусламжаас илүү чухал» хэмээн сурталчилж байв. Гэвч ВХН-аас энэ бүх илэрлийг тэр даруйд нь таслан зогсоосон учир тэдний хорлон бусниулах энэ оролдлогод нь сүрхий цохилт болсон юм.

1968 онд Америк-Вьетнамын хэлэлцээг Хятад жадлан эсэргүүцэв. Энэ нь вьетнамын дайныг сунжруулах, олон улсын намжмал байдалд бэрхшээл учруулах, Америк-Зөвлөлтийн харилцааг ээдрээтэй болгон хүндрүүлэх зорилготой байв. Тэр үед БНХАУ-ын ерөнхий сайдын орлогч байсан Чэнь И. Вьетнамын удирдагчдад «хэрвээ Вьетнам АНУ-тай хэлэлцээгээ үргэлжлүүлбэл ХКН, ВХН-ын хэлхээ харилцаа тасрах болно» гэж шууд мэдэгдэж байлаа.³

Гэвч америкийн түрэмгийлэл улам бүр мухардалд орж «дайныг вьетнамчлах» замаар тэрхүү хүнд байдлаас мултрах арга зам хайх болсон 70-аад оноос эхлэн Бээжингийн эрх баригчдын санал 180 градус эргэж Вьетнам-Америкийн хэлэлцээг зөвшөөрөн «Вьетнам зөв, бид анхандаа Вьетнамыг мэхлэгдлээ гэж айж байсан юм» гэх зэргээр зулгуйдаж эхлэжээ. Үүний учир шалтгаан нь Бээжин, Вашингтон хоёр ам хэлээ ололцон, улам ойртон түншлэх болсонтой холбоотой юм. Чухам энэ үеэс эхлэн вьетнамын ард түмний эсрэг америкийн империализмтай илт хуйвалдан, Вьетнамыг жанжлан түрэмгийлэх санаархлаа ямар ч халхавчгүй хэрэгжүүлэхийг бээжингийн эрх баригчид оролдсон юм.

Хятадын эрх баригчид 1971 онд Киссинжерийг, 1972 онд Никсоныг тус тус хүлээн авч, Зүүн өмнөд Ази дахь АНУ-ын түрэмгий бодлогыг дэмжиж байгаагаар илэрхийлсэн нь вьетнамын ард түмний тэмцэл ялалтанд саад учруулах гэсэн л оролдлого байв. 1972 оны 2-р сарын 28-нд Зүүн өмнөд Азийн орнуудын улс төрийн дэглэмийг, түүний дотор Өмнөд Вьетнам дахь Тхивеүгийн дэглэмийг хэвээр байлгах тухай тохиролцсон Шанхайн мэдэгдэлд гарын үсэг зурсан явдал нь империализм, хятадын их гүрний жанжлах үзэлтний хооронд нягт хэлхээ холбоо тогтоосны анхны албан баримт бичиг юм. Хятадын эрх баригчдын энэ явууллагатай холбогдуулан ВХН-ын төв хэвлэл «Нянзян» сонин 1972 оны 8-р сарын 17-нд «Дэлхийн хувьсгалт чиглэлийн ялалт» хэмээх тэргүүн өгүүлэл нийтэлж, «Нэг улс өөрийн явцуу эрх ашгийн үүднээс интернационалч эрхэм дээд үүргээ умардах нь дэлхийн хувьсгалт хөдөлгөөнд төдийгүй,

¹ Бюллетень информации АПН. 1979. V №20.

² Дейли уорлд. 1979. II.

³ Бюллетень информации АПН. 1979. V. № 20

эцсийн эцэст өөрийн ард түмэнд нөхөж баршгүй хохирол учруулах болно»¹ гэж бичжээ.

Бээжингийн эрх баригчидтай Энэтхэг-Хятадын хойгийн асуудлаар санаа бодлоо ойлголцсоны дараа АНУ 1972 оны 12-р сард Ханой хотыг Б-52 хэмээх хүнд бөмбөгдөгч онгоцоор өдөр шөнөгүй бөмбөгдөж, Тонки-ны буланг минжүүлсэн юм.

Гэвч эд бүхэн нь амжилтанд хүрээгүй юм. 1973 оны 1-р сард АНУ арга буюу Парисийн хэлэлцээрт гарын үсэг зурж, Парисын хэлэлцээ Вьетнамын ялалтаар төгсмөгц хятадын эрх баригчид Вьетнамд үзүүлж байсан тусламжаа зогсоосноор барахгүй АНУ-тай нууцаар тохиролцсоны үндсэн дээр (Тхиеү-гийн дэглэмийн цэрэг байрлаж байсан) Вьетнамын Параселийн хэсэг аралд цэргийн десант буулгаж эзлэн авчээ.

1975 онд Өмнөд Вьетнам бүрэн чөлөөлөгдөн, Сайгоны дэглэм унаж, энхийг эрхэмлэсэн нэгдсэн социалист Вьетнам улс бий болсон явдал Шанхайн гэрээний дагуу Тхиеү-гийн дэглэмийг хэвээр байлгахын тулд Хятадын зүгээс тус хүргэх, түүний оронд АНУ Тайвань-аас цэргээ гаргах, үүний үндсэн дээр Хятад-Америкийн харилцааг улам бататгах ёстой байсан Бээжингийн төлөвлөгөөг нурааснаас гадна Энэтхэг-хятадын хойг болон нийт Зүүн өмнөд Азийг жанжлах Бээжингийн төлөвлөгөөнд хүнд цохилт болжээ. Чухамхүү энэ үеэс эхлэн БНСВУ-ын эсрэг дайсагнасан явууллагаа хятадын эрх баригчид ихээхэн идэвхжүүлж, нэгдсэн Вьетнам улсыг элдвээр хяхан хавчиж айлган сүрдүүлэх замаар эрхшээл нөлөөндөө оруулахыг эрмэлзсэн юм.

Тэд нэг талаас Пол Потын харгис бүлгийг гар хөл болгон ашиглаж, Вьетнамын баруун өмнөд хилд өнгөлзөн, нөгөө талаас «хэлмэгдэгч цагаачдын асуудал» гэгчийг гаргаж ирэв. Тэд чухамхүү үүгээр шалтаглан БНСВУ-д эдийн засаг-техникийн тусламж үзүүлэх явдлаа дур мэдэн зогсоож мэргэжилтнүүдээ татсан төдийгүй бусад орныг ч Вьетнамд туслахгүй байхыг уриалж Вьетнамын эдийн засагт ноцтой бэрхшээл учруулахыг оролдов. Үүний зэрэгцээ Хятадын тал Хятад-Вьетнамын хил дээр удаа дараа будлиан гаргах болж, «Вьетнам улс Хятадын эсрэг өдөөн хатгалга хийж байгаа» мэтээр гүтгэлгийн суртал нэвтрүүлгийн өргөн кампанит ажил зохиов.

Улс төр, эдийн засаг, цэргийн энэхүү даралт хавчилтын аргаар бээжингийн эрх баригчид Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсыг буулган авч, өөрийн нөлөөнд оруулж чадна гэж боджээ. Гэвч БНСВУ эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн бүрэн эрхт гишүүн болж, социалист байгуулалтын хурдцыг түргэтгэх үндсэн нөхцлийг бүрэлдүүлсэн төдийгүй, дэлхийн ууган социалист орон ЗХУ-тай найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байгуулж, эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататгасан явдал хятадын санаархалд эрс шийдвэртэй цохилт болсон юм.

Мөн түүнчлэн Кампучид Бээжингийн жанжлал бүрмөсөн ялагдаж, Пол Пот-Иенг Сарийн харгис дэглэм балран унасан явдал хятадын эрх баригчдын жанжлах түрэмгий бодлогод бас том цохилт болсон юм. Энэ бүхэнд хилэгнэн хорссон бээжингийн жанжлагчид БНСВУ-ыг хорсон занаж түүний эсрэг зэвсэгт түрэмгийллийн замыг сонгон авчээ.

БНСВУ-ын эсрэг хятадын түрэмгийлэл эхлэсэнтэй холбогдуулан БНСВУ-ын засгийн газар мэдэгдэл нийтэлж, Вьетнамын эсрэг чиглэсэн хятадын эрх баригчдын дайсагнасан бодлого байнгын ялагдал хүлээж байснаас болж, тэд хятадын хаад, феодал ноёд, милитаристууд колонилогчдын замд орж, тусгаар тогтносон бүрэн эрхт Вьетнамын эсрэг түрэмгий дайн дэгдээж байгаа нь тодорхой байна гэж мэдэгдсэн билээ.

¹Нянзян, 1972. VIII. 17

Хятадын эрх баригчдын үйлдсэн энэ түрэмгий дайны зорилго нь тодорхой бөгөөд юуны өмнө БНСВУ-ыг эзэлж Пол Потын дээрэмчдийн хуучин дэглэмийг сэргээх, улмаар БНАЛАУ-д халдан довтолж, Энэтхэг-Хятадын хойгт болон цаашилбал Зүүн өмнөд Азийн бусад орнуудад түрэмгийлэн эдгээрийг өөрийн түшиц болгох гол зорилго агуулжээ. Маогийнхан өөрийн түрэмгийллийн зорилгыг нуун далдалж, БНСВУ-ыг хятадын эсрэг өдөөн хатгалга үйлдэж «орон нутгийн жанжлах» бодлого явуулж байгаа мэтээр гүтгэн Вьетнамыг «хашраах», «сөрөг цохилт» хийж байгаа мэтээр дэлхийн олон нийтийг хууран мэхлэхийг оролдсон юм. Хятадын энэ зэвсэгт түрэмгийлэл нь цар хэмжээгээрээ сүүлийн үед гарсан дэлхийн томоохон зэвсэгт түрэмгийллийн нэг байв. Энэ дайнд хятадын жанжлагчид (Кунминь, Гуанчжоу, Чэнду, Ухань зэрэг цэргийн дөрвөн тойргийн явган цэргийн 9 корпус бие даасан 7 дивиз (цэргийн тээврийн машиныг оролцуулалгүйгээр), 550 танк, хуягт тээвэрлэгч олон мянган хүнд их бууг дайчлан оролцуулснаас гадна 580 нисэх онгоцыг байлдааны бэлэн байдалд байлгажээ. Энэ түрэмгийлэлд оролцсон хятадын цэргийн тоо 1950-аас 1953 онд Солонгосыг түрэмгийлэхэд оролцсон АНУ-ын цэргийнхээс бараг 2 дахин, 1967 онд Араб, Сири, Иорданыг довтолход оролцсон Израилийн цэргийнхээс 6 дахин, 1962 онд Энэтхэгийг түрэмгийлэхэд оролцсон хятадын цэргийнхээс 2,2 дахин их төдийгүй Вьетнамын эсрэг дайнд оролцсон АНУ-ын цэргийн хамгийн дээд хэмжээнээс давжээ.¹

Хятадын цэрэг БНСВУ-д түрэмгийлэн довтолсон анхны өдрөөс эхлэн хүрсэн газар бүртээ зэрлэг ялт ажиллагаа үйлджээ. Хятадын олзлогдсон цэргүүд үйлдсэн ялт хэргээ нуухгүй тоочсоор байхад бээжингийн суртал нэвтрүүлэг «хятадын цэргүүд Вьетнамын өрх айлуудад хоол хүнснээсээ өгч хөгшид, хүүхдий нь асран халамжилж» байсан мэтээр үнэн байдлыг мушгин гуйвуулж хятадын болон дэлхийн олон нийтийг төөрөгдүүлэхийг хичээжээ. Хятадын түрэмгийлэгчдээс 1979 оны 3-р сарын эцэс хүртэл БНСВУ-д учруулсан хохирлыг БНСВУ-ын нийтэлсэн бүрэн бус мэдээнээс үзвэл дөрвөн мужийн төв, 300 гаруй тосгоныг бүрэн сүйтгэж, наад зах нь 20 мянга гаруй хүнийг орон сууцгүй болгосноос гадна 900 гаруй сургууль, 700-аад яслы, цэцэрлэг, 430 эмнэлгийн салбарыг эвдэж нураасан байна.² Бээжингийн эрх баригчид БНХАУ-ын газар нутагт огтхон ч халдаагүй БНСВУ-ын эсрэг өргөн цар хүрээтэй түрэмгий дайн үйлдсэнээрээ улс түмний болон хүний үндсэн эрхийг улан дороо гишгэж, НҮБ-ын дүрэм, хүний эрхийн тухай тунхаглалыг хөсөрдүүлсэн юм. Тэд энгийн номхон ард иргэдийг алах, тамлан зовоох, эд хөрөнгийг нь дээрэмдэх, цэргийн аливаа зориулалтгүй барилга байгууламж, хот, тосгодыг эвдэн сүйтгэх зэрэг гэмт хэргийг үйлдсэн байна. Тэд дайны үед энгийн номхон ард иргэдийн амь насыг хамгаалах тухай 1949 оны 8-р сарын 12-ны Женевийн конвенцийг зөрчжээ.

Хятадын зэвсэгт халдлага эхлэсэн анхны өдрөөс эхлэн энэ түрэмгийллийн мөн чанарыг илчилсэн хөдөлгөөн дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрт өрнөсөн билээ. БНСВУ-ын эсрэг хятадын зэвсэгт түрэмгийлэл эхэлмэгц юуны өмнө Вьетнамын ард түмний үнэнч хань социалист хамтын нөхөрлөлийн орнууд, түүний дотор БНМАУ-ын засгийн газар, монголын олон нийт хятадын түрэмгийлэгчдийг зэмлэн буруушааж, цэргээ Вьетнамаас нэн даруй татан гаргахыг бээжингийн эрх баригчдад хатуу шаардаж байв.

ЗХУ-ын засгийн газрын мэдэгдэлд «ЗСБНХУ, БНСВУ-ын хоорондын найрамдал хамтын ажиллагааны тухай гэрээгээр хүлээсэн үүргээ ЗХУ

¹«Нянзян», 1979. IV. 5

²«Нянзян» 1979. V. 17

биелүүлнэ. Бээжингийн улс төрийн бодлогыг тодорхойлогч хүмүүс хожимдоогүй дээрээ түрэмгийллээ зогсоовол зохино»¹ гэсэн жинтэй сануулгыг хятадын түрэмгийлэгчдэд өгсөн явдал бээжингийн дайны хэнээтнүүдийн балмад явууллагыг таслан зогсоосон шийдвэрлэх хүчин зүйл болсон билээ. «Хятадын түрэмгийлэгчид Вьетнамаас савраа тат!» гэдэг хөдөлгөөн социалист хамтын нөхөрлөлийн орнуудаас эхлэн дэлхий даяар өрнөсөн бөгөөд энэ хөдөлгөөнд социалист болон найрамдалт орнуудын 50 гаруй засгийн газар, коммунист ажилчны 60 гаруй нам, олон улсын ардчилсан олон байгууллага оролцсон байна. Дэлхийн олон нийтийн ийм хүчирхэг шахалтаас гадна хятадын түрэмгий цэрэг БНСВУ-д түрэмгийлэн довтолсон анхны өдрөөс эхлэн социалист Вьетнамын зэвсэгт хүчний хүнд цохилт авсан юм. Орчин үеийн дайнд бээжингийн бодсончилон цэргийн олон нь шийдвэрлэх хүчин зүйл биш гэдэг нь тодорхой болсон бөгөөд байлдааны талбар дээр хятадын ихээхэн хэмжээний цэрэг Вьетнамын зэвсэг хүчинд бутцохигдож байлаа. Францын цэргийн мэргэжилтнүүд «Монд» сонинд бичсэнээр Вьетнамын байнгын арми, түүний шилмэл хүчин болсон агаарын цэргийн хүчин, пуужингийн анги, танк, их буу, өөрөөр хэлбэл Вьетнамын жинхэнэ хүчин чадлыг харуулах цэргийн төрлүүд бүгд байлдаанд оролгүй бүхэл бүтнээрээ фронтын ар талд зогсож байжээ.² Хятадын гүрэмгий цэрэг хоёрхон долоо хоногийн дотор вьетнамын цэрэгт гол хүчээ цохиулж бүслэгдсэнээс гадна гучаадхан хоногийн дотор БНХАУ бүх цэргийнхээ аравны нэгийг буюу 62500 цэргээ устгуулж танк хуягт тээвэрлэгчийнхээ тавь гаруй хувийг жагсаалаас гаргуулж үлэмжхэн тооны зэр зэвсэг, байлдааны хэрэгсэл олон зуун цэргээ олзлуулсан байна.

Бээжингийн эрх баригчид Вьетнамын фронт дээр ийнхүү хүнд цохилт хүлээхийн хамт түрэмгий дайны улмаас улс орны дотоодод нь зөрчил тэмцэл хурцдаж, хятадын дотоод улс төрийн байдал улам тогтворгүй болжээ.

Энэ бүхний улмаас хятадын түрэмгийлэгчид арга буюу ялагдалд орж цэргээ татахад хүрсэн юм. Үүнтэй холбогдуулан Вьетнамын Коммунист Намын төв хэвлэл «Нянзян» сонин бичихдээ: «манай арми, манай ард түмнээс хүнд цохилт авч, дэвшилт бүх олон нийтийн хилэнт дургүйцэл, хятадын өөрийнх нь ард түмний эсэргүүцлийн хүчирхэг давалгаа, дотоодын хурц зөрчилтэй тулгарснаар бээжингийн эрх баригч бүлгийнхэн цэргээ арга буюу татахад хүрлээ»³ гэсэн билээ. БНСВУ-ын эсрэг үйлдсэн хятадын энэ түрэмгийлэл нь Бээжингийн эрх баригчид газар бүхний хэт харгис хүчинтэй сүлбэлдэж олон улсын империализмын бэлтгэл хүч болж байснаа шууд холбоотон нь болж, дэлхийн энх тайван, социализм, улс түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын заналт дайсан болсныг дэлхий нийтэд улам тод харуулав. Бээжингийн эрх баригчдын өдүүлсэн зэвсэгт түрэмгийлэл шившигтэйгээр ялагдсан явдал империализм, дайн өдөөгчдийн эсрэг энх тайван, социализмын хүчин ялагдашгүйг дахин нотолж бээжингийн их гүрний эзлэн түрэмгийлэх бодлого дампуурах тавилантайг харууллаа.

Хятадын түрэмгийлэгчид шившигтэйгээр ялагдсан боловч одоо үед БНСВУ-ын эсрэг дахин зэвсэгт түрэмгийлэл хийхээр заналхийлж, түүний хилийн дагуу дайны цэрэг зэвсгийн хүч бөөгнөрүүлэн цэрэг стратегийн ач холбогдолтой зам тавьж, зарим үед хил хязгаарыг нь зөрчсөөр байна. Сүүлийн үед Вьетнамын хилийн дагуу хятадын цэргийн тоо үлэмж нэмэгдэж шууд хилийн ойролцоо төвлөрч байгаа тухай Вьетнамын «Куан дой нянзян» сонин мэдээлж байна. Одоо Вьетнамын хил дээрх цэргийн тоо 1979 оны 2-р сарынхаас 2 дахин нэмэгдээд байна, Тэрчлэн хятадын

¹«Правда» 1979. II. 18

²«Монд» 1979. III. 3. «Нянзян», 1979. IV. 5.

³«Нянзян» 1979

явган цэрэг тэнгисийн болон агаарын цэрэг, тэнгисийн десантын цэргийн олон ангиуд хил залгаа газруудаар байлдааны сургууль тасралтгүй хийж байна.

Бээжингийн дайны хэнээтнүүд Вьетнамын эсрэг түрэмгийлэлд оролцсон хятадын цэргүүдийг «өөрийгөө хамгаалж Вьетнамыг бут цохьсон байлдааны баатрууд» хэмээн өргөмжилж, тэдний «гавьяаг» магтан, тэдний үлгэр жишээнээс суралцах хөдөлгөөнийг хятад даяар хэдэн сарын турш өрнүүлж Вьетнамын эсрэг дахин түрэмгийлэхэд хятадын хүн ам, цэрэг, армийг санаа сэтгэлийн хувьд бэлтгэж байна.

Үүний зэрэгцээ Бээжингийн эрх баригчид «дүрвэгсдийн асуудал» гэгчийг дэвэргэж Кампучи дахь хувьсгалт өөрчлөлт хийгээд ЗХУ-ын тусламж дэмжлэгийн мөн чанарыг мушгин гуйвуулж, Вьетнамын нэр хүндийг гутаах гэсэн элдэв оролдлого хийж байна.

Хятадын эрх баригчид БНСВУ-д «орон нутгийн жанжлагчид», «зөвлөлтийн гар хөл» гэсэн хаягийг зүүж түүнийгээ нотлохын тулд Вьетнам улс Кампучийг эзлэн түрэмгийлээд Лаосыг хяналтандаа оруулсан мэтээр гүтгэлгийн суртал нэвтрүүлэг хийж байна.

Сүүлийн үед тэд бүр эрээ цээрээ алдаж ЗХУ-ын тусламжийн мөн чанарыг гуйвуулж, Вьетнамыг зөвлөлтийн цэргийн бааз болж байгаа мэтээр ярих боллоо. Энэ бүхэн нь шинэ түрэмгийлээ эхлэхийн өмнө бээжингийн эрх баригчид Вьетнамын нэр хүндийг аль болохоор унагааж түүнийг ганцаардуулах гэсэн оролдлого юм.

Хятадын эрх баригчид одоо Вьетнамын эсрэг зэвсэгт түрэмгийлэлд улангасан бэлтгэж байгаагаар илт ярих болж, хятадын ард түмний санаа сэтгэлийг үүнд чиглүүлж байна. Хятадын талын буруугаас болж, Вьетнам-Хятадын хэлэлцээ тасарсныг бас Вьетнамд тохихыг хятадын эрх баригчид хичээж байна. Вьетнамын засгийн газар маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг хичээн эрмэлзэж Вьетнам, Хятадын хил дээр энх тайван, тогтвортой байдлыг ханган тус хоёр орны хоорондын сайн хөршийн найрсаг харилцааг сэргээн тогтооход чиглэсэн арга хэмжээ авах тодорхой программ дэвшүүлсээр байтал хятадын тал огт хүлээн авч болшгүй шаардлага тавьж Вьетнам улсыг бие даасан бодлогоос нь татгалзуулан, дэлхийн социализмаас салгаж, хятадын эрхшээлд оруулах гэсэн шаардлага тавьсан юм.

Вьетнамын эсрэг хятадын үйл ажиллагаа империалист хүчин, юуны өмнө америкийн империализмын дэмжлэгийг улам их авч байна. АНУ-ын харгис бүлгийнхэн Вьетнамын эсрэг хийсэн хятадын түрэмгийллийг далдуур дэмжиж уг түрэмгийллийг таслан зогсоох саналыг Кампучиас Вьетнамын цэргийг гаргах асуудалтай холбон тавьснаараа хятадын түрэмгийлэлд тус дөхөм үзүүлж байна. Империалист харгис хүчин, «дүрвэгсдийн асуудал» гэгчээр Хятадтай дуу хоолойгоо нийлүүлээд зогсоогүй бодлогоо уялдуулан зохицуулж байна. Хятадын эрх баригчид Вьетнамын хил рүү өнгөлзөх ажиллагаагаа хүчтэй болгож байгаа үед АНУ-ын 7-р флотын хөлөг онгоцнууд «дүрвэгсдийг хайх» нэрийдлээр Өмнөт Хятадын тэнгист орж Вьетнамын өмнө талаас өдөөн хатгаж байна.

БНХАУ байгуулагдсанаас хойш хятадын их гүрний дээрэнгүй үзэлтнүүдээс Вьетнамыг жанжлах гэсэн түүхэн үнэнийг товч дүгнэхэд, БНХАУ оршин тогтносон эхний жилүүдэд маогийнхан БНАВУ-ыг талархдаг дүр үзүүлж байсан төдий нь 60-аад онд бүр ч тод илэрч БНАВУ-д улс төр, үзэл суртлын элдэв даралт шахалт үзүүлэх болжээ. Харин БНХАУ 70-аад онд улс төр, үзэл суртлын шахалтаа цэрэг, эдийн засгийн шахалтаар сольж, 70-аад оны сүүл үеэс цэрэг зэвсгийн хүчээр шууд түрэмгийлэн эзлэх замд оржээ.

Энэ нь БНСВУ-ыг шунахайран эзлэх гэсэн Бээжингийн бодлого аюултай шатанд орсныг харуулж байгаагаас гадна Хятадын энэ бодлого нь

Ази болон даян дэлхийн улс түмний энх тайван, аюулгүй байдлыг түйвээн үймүүлэх, олон улсын намжмал байдлын үйл явцыг тасалдуулж, «хүйтэн дайны» байдалд эгүүлэн оруулах маш аюултай бодлого юм.

Бээжингийн эрх баригчдын энэ бодлогын аюулыг МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю-Цэдэнбал заан хэлэхдээ, «Хятадын эрх баригч бүлгийнхэн эзлэн түрэмгийлэх зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор дахин цэрэг дайны адал балмад түрэмгийлэл үйлдэхгүй гэхийн баталгаагүйг тэдний улс төрийн бодлого практик ажиллагаа нотолж байна. Энэ бол Хятадтай хил залгаа оршдог ямар ч орон хятадын эрх баригчдын түрэмгий явууллагын бай болж болзошгүй гэсэн хэрэг»¹ гэсэн билээ. Империалист харгис хүчний шууд холбоотон болсон хятадын маоист эрх баригчид их гүрний жанжлах бодлого түрэмгий үйл ажиллагаагаараа даян дэлхийн энх тайван, улс түмний аюулгүй байдалд ноцтой занал учруулж байгааг хятадын их гүрний дээрэнгүй жанжлах үзэлтнүүдээс БНСВУ-ын эсрэг явуулж байгаа уламжлалт эзлэн түрэмгийлэх бодлого улам бүр тод харуулж байна.

С. Дашцэвэл

АГРЕССИВНАЯ ПОЛИТИКА КИТАЙСКИХ. ГЕГЕМОНИСТОВ ПРОТИВ СРВ

Р е з ю м е

В феврале 1979 г. пекинские руководители, грубо поправ международные права и принципы ООН, совершили вооруженную агрессию против Социалистической Республики Вьетнам. Агрессия против СРВ является наиболее открытым продолжением политики аннексии и экспансии Китая, унаследованной им же из прошлого.

Еще на Женевской конференции 1954 г. китайское руководство добивалось сохранения раздела Вьетнама с тем, чтобы включить его в свою орбиту. Дальнейшие события, когда в середине 60-х годов китайские руководители во главе с Мао Цзедунем оказались заинтересованными з дальнейшей эскалации американской агрессии против Вьетнама, уже свидетельствовали об антивьетнамском характере китайской внешней политики. Эта же политика Пекина в отношении Вьетнама, в свою очередь, послужила основой для сближения Китая с Соединенными Штатами. 3 1971 г. китайские руководители приняли в Пекине Г. Киссинджера, а в начале 1972 г. Р. Никсона. С тех пор Пекин все более углублял враждебные действия против СРВ. Помогая Вашингтону выпугаться из безнадежной грязной войны во Вьетнаме. Пекин начал оказывать давление на ДРВ и Национальный Фронт освобождения Южного Вьетнама с тем, чтобы они свернули фронт борьбы против американской агрессии, согласились на сохранение реакционного проимпериалистического режима на юге страны. Китай прекратил военную помощь Вьетнаму и после подписания парижского соглашения отнюдь не спешил с выполнением его обязательств, а также ранее подписанных экономических соглашений с Вьетнамом.

В 1974 г при поддержке США Китай захватил принадлежащие Вьетнаму Парассельские острова и предъявил претензии на острова Спратли. Таким образом, на всем протяжении борьбы вьетнамского народа против

¹ «Үнэн» 1979. 4. 26

американского империализма правители Китая вынашивали коварные замыслы, один за другим совершали враждебные действия против Вьетнама.

Историческая победа вьетнамского народа в их борьбе против американской агрессии в 1975 г., достигнутая ими с помощью и поддержки народов социалистических стран, воссоединение Севера и Юга страны, реализованное вопреки «советам» Пекина, шли вразрез с великодержавными и антивьетнамскими планами китайских руководителей. Именно, поэтому, Пекин подстрекал клику Пол Пота-Иенг Сари против Вьетнама, пытался организовать на территории СРВ «пятую колонну» с помощью этнических китайцев, тем самым готовил пещу для своей агрессии против Вьетнама.

Открытая вооруженная агрессия Китая против СРВ явилась кульминационным пунктом его антивьетнамских враждебных действий и окончательно раскрыла перед всем миром сущность демагогических лозунгов нынешних китайских лидеров. Победа героического вьетнамского народа над Пекином еще раз продемонстрировала непоколебимую волю освобожденного народа. Она также показала, что великодержавный экспансионизм Пекина обречен на неизбежный провал.

Однако, пишет автор, пекинские лидеры, движимые своими гегемонистскими, агрессивными устремлениями, упорно не хотят примириться с поражением и всячески стремятся взять реванш. Об этом свидетельствует активизация враждебных действий Пекина на вьетнамо-китайских границах.